



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 415

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө балансаас балансад ┐
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчит зарим байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 4 нэрийн нийт 129,155,301.52 (нэг зуун хорин есөн сая нэг зуун тавин таван мянга гурван зуун нэг төгрөг тавин хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, 108,749,716.58 (нэг зуун найман сая долоон зуун дөчин есөн мянга долоон зуун арван зургаан төгрөг тавин найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг (зарим үлдэх өртөггүй хөрөнгийн ашиглах хугацааг сунган үнийг шинэчлэн тогтоож) хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Тогтоолын хавсралтад заасан төрийн өмчит байгууллагын дарга, захирал, "Засгийн газрын автобааз" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

137005944
22-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн
11/11 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИТ ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНУУДЫН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгө эзэмшигч төрийн өмчит байгууллага	Автомашинны нэр, марк дугаар	Үйлдвэр- лэсэн он /Ашиглал- тад орсон он	Хөрөнгийн балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага	Шинэчлэн тогтоосон үнэ	Цаашид ашиглах хугацаа
1	Оюуны өмчийн газар	Хьюндай Соната-6 0944УБП /арал № КМНЕТ41ВР8А460892/	2008/2008	19,000,000.00	19,000,000.00	"Баянчандмань АЗЗА" ТӨХК	3,000,000.00	2
2	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	Тоёото Ландкрузер-100 0096ДГС /арал № JTENT05J462099717/	2006/2013	68,000,000.00	47,594,415.06			
3	Төрийн тусгай хамгаалалтын газар	Хьюндай Соната-6 1164УНУ /арал № КМНЕТ41СР7А257349/	2006/2006	23,155,301.52	23,155,301.52	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь МСҮТ	3,000,000.00	2
4	Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ	Хьюндай Соната-6 1399УБУ /арал № КМНЕТ41АР8А515747/	2008/2011	19,000,000.00	19,000,000.00		3,000,000.00	2
				129,155,301.52	108,749,716.58		9,000,000.00	
Нийт дүн				(нэг зуун хорин есөн сая нэг зуун тавин таван мянга гурван зуун нэг төгрөг тавин хоёр мөнгө)	(нэг зуун найман сая долоон зуун дөчин есөн мянга долоон зуун арван зургаан төгрөг тавин найман мөнгө)		(есөн сая төгрөг)	